



COVID-19-ийн дэгдэлтээс болж хаагдсан сургууль дахин хичээллэж эхлэх болсонтой холбоотойгоор эцэг эх асран хамгаалагчдад зориулсан зөвлөмж

First date school was non-operational

Сургууль хаагдсан анхны өдөр

Final date school was non-operational, if more than one day

Нэгээс олон өдрөөр хаагдсан бол сургууль хаалттай байсан сүүлийн өдөр

COVID-19-ийн дэгдэлт гарсан нь тогтоогдсон тул дээр дурдсан өдрүүдэд сургууль хаалттай байсан болно.

Хаалттай байх хугацаанд сургуульд нарийн цэвэрлэгээ хийгдсэн ба дараах өдөр танхимын сургалтыг дахин эхлүүлэх болно:

Date for resumption of on-site learning

Танхимын сургалт дахин эхэлсэн огноо

Сургуулийн багш ажилчид, сурагчдын эрүүл мэнд, аюулгүй байдал ямагт хамгаас илүү чухал юм. NSW муж улсын Боловсролын яам нь NSW муж улсын эрүүл мэндийн албатай нягт холбоотойгоор бүх багш ажилчид болон сурагчдын эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангаж ажиллах болно. Үүнд халдвар тараагчтай ойрын хавьталд орогсдыг олж тогтоон тэдэнтэй шууд харилцан өөрийгөө тусгаарлах шаардлагатай танилцуулах арга хэмжээ орно.

Ойрын хавьталд орсон нь тогтоогдсон сурагч, ажилчдад тодорхой тогтоосон хугацаагаар өөрсдийгөө тусгаарлаж, хорионы хугацаа өнгөртөл сургуульд ирэхийг хориглосон талаар мэдэгдсэн болно.

Тогтоосон завар журмын дагуу өдөр тутмын цэвэрлэгээг хийх, ариун цэврийн дэглэмийг сахихын чухалыг хөхүүлэн сурталчлах, бүх багш ажилчид, сурагчдыг сургуульд байх хугацаанд гар ариутгагчаар хангах зэргээр халдвараас урьдчилан сэргийлэх, хянах талаар сургууль өндөр анхаарал тавин ажиллах болно.

Сургуулийн багш ажилчид, сурагчдын эрүүл мэнд, аюулгүй байдал ямагт хамгаас илүү чухал юм. Бид NSW эрүүл мэндийн албатай нягт холбоотойгоор шаардлагатай бүхий л зөвлөмжийг мөрдөн ажиллах болно.

COVID-19-ын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг англи хэл дээр болон [бусад хэл дээрх орчуулгын](#) хамт [NSW Health website](#)-аас олж үзнэ үү.

COVID-19-ийн дэгдэлтийн эсрэг NSW муж улсын Боловсролын яамны авч явуулж буй арга хэмжээний талаарх нмэлт мэдээллийг <https://education.nsw.gov.au/covid-19>

Утсан Орчуулгын Үйлчилгээ

Хэрвээ та дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл сургуулийн захиралтай утсаар холбогдоорой. Хэрвээ таньд орчуулагч хэрэгтэй бол Орчуулгын Үйлчилгээний 131 450 дугаараар холбогдон өөрийн хэл дээрх орчуулагчийг захиалж болно. Утасны операторт та холбогдох гэж буй утасны дугаараа хэлвэл оператор шугамд орчуулагчийг холбож танд утсаар ярих боломжийг олгох болно. Энэ үйлчилгээ нь үнэ төлбөргүй.